

# **Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа 2002-2003 он**

## **ТОВЧ ДҮГНЭЛТ**

Энэ тайлангаар “Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний 2002-2003 оны түүвэр судалгааны” (ӨОЗАТС) үр дүнгээр хийсэн ядуурлын дүн шинжилгээг танилцуулж байна. Шинжилгээний үндсэн зорилго нь: 1) Монгол улсын ядуурлын байдлын шинэчилсэн тооцоонуудыг бүс нутаг болон байршилаар (хот, хөдөө) хийх; 2) ядуу хүн амыг ядуу бус хүн амаас ялгах үндсэн шинж чанарыг тодорхойлон, ядуурлын дүр төрхийг илэрхийлэхэд оршино.

### **Монгол улсын эдийн засгийн байдал**

“Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшин”-ий судалгаа явагдахын өмнөх жилүүдэд эдийн засгийн өсөлт маш бага буюу 1999-2002 онд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ зэрэгцүүлэх үнээр ердөө 2 хувиар өсчээ. Ялангуяа цаг уурын тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалан олон тооны мал хорогдсон нь хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний өсөлтийг бууруулсан. Нөгөө талаас аж үйлдвэр, үйлчилгээний салбаруудын үйл ажиллагаа сэргэн эдгээр салбаруудын бүтээгдэхүүн, үйлчилгээний өсөлт нь аж үйлдвэрийн салбарт 24, үйлчилгээний салбарт 44 хувь боллоо. Сүүлийн 5 жилд Монголын эдийн засагт нилээд өөрчлөлтүүд гарав. 1999-2002 онд Дотоодын нийт бүтээгдэхүүнд (ДНБ) хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувийн жин 36.5 хувь байснаа 20.1 хувь болж бараг хоёр дахин буурав. ДНБ-ний бүтцийн энэ өөрчлөлт нь ХАА-н салбарын огцом уналт болон аж үйлдвэр, үйлчилгээний салбарын бодит өсөлтөөс аль алинаас нь шалтгаалсан.

### **Ядуурлын хэмжигдэхүүн**

Амьжиргааны доод шугамыг үндэслэн ядуурлын хамралтын хүрээг тодорхойлоход нийт хүн амын 36.1 хувь нь ядуу байгаа ба ядуурал өргөн тархсан үзэгдэл болоод байна. Ядуурлыг тодорхойлогч бусад хэмжигдэхүүнүүд болох ядуурлын гүнзгийрэлт, ядуурлын мэдрэмжийн индекс нь ядуучуудын дунд тэгш бус байдал их байгааг харуулж байна. Үүнд ядуурлын гүнзгийрэлтийн индекс 11.0 хувь, ядуурлын мэдрэмжийн индекс 4.7 хувь байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд ядуурал нэмэгдсэн байдал харагдах боловч хөдөө аж ахуйн салбарын их уналтыг авч үзвэл ийм дүгнэлт хийх нь хязгаарлагдмал юм.

### **Тэгш бус байдал**

Жини коэффициентээр тэгш бус байдлыг хэмжихэд 0.33 байгаа бөгөөд энэхүү тэгш бус байдал нь хот суурин газруудад хөдөөнөөс илүү байна. Хүн амын хамгийн чинээлэг 20 хувь нь хамгийн ядуу 20 хувиас 5.5 дахин их хэрэглээтэй байна.

## Ядуучуудын ерөнхий байдал

Хөдөөтэй харьцуулахад хот суурин газруудад ядуурал харьцангуй доогуур байгаа бөгөөд хотод 30 хувь, хөдөөд 43 хувь байна. Ядуурлын түвшин Улаанбаатар хотод хамгийн бага ба ядуу 9 хүний 5 нь сумын төв, хөдөөд, харин нийт ядуу хүн амын гуравны нэг нь хөдөөд (сумын төвөөс өөр газарт) амьдарч байна. Ядуурлын хамралтын хүрээний бууралт зүүн бүсийн аймгуудад илүүтэй байна. Баруун бүсийн хүн амын тал хувь нь ядуу байхад зүүн бүсийн хүн амын гуравны нэг орчим нь ядуу байна.

Монгол Улсын хүн амын амьжиргаанд улирлын нөлөөлөл байдаг нь тодорхой. Судалгаанаас үзэхэд ядуурлын хамралтын хүрээ хоёр, дөрөвдүгээр улиралд жилийн бусад улирлуудаас 5 пунктээр өндөр байгаа нь мал аж ахуй эрхлэлтийн улирлын үйл ажиллагаа болон цаг уурын нөхцлөөс голлон хамаарч байна.

Өрхийн ядуурлын түвшин нь өрхийн тэргүүлэгчийн зарим шинж байдлаас хамааралтай байна. Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин өндөр байхын хэрээр тухайн өрх ядууралд өртөх нь бага, тухайлбал өрхийн тэргүүлэгч нь бүрэн дундаас доош боловсролтой байгаа өрхийн хүн амын бараг тал хувь нь ядуу байхад бакалавр, түүнээс дээш боловсролтой өрхийн тэргүүлэгчтэй өрхүүдийн есний нэг нь ядуу байна. Хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын амьжиргаа нь үйлчилгээний салбарынхнаас доогуур байгаагаас тэдний хувьд ядууралд өртөх магадлал илүү байна. Төрийн өмчийн, аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын амьжиргааны түвшин харьцангуй сайн байна. Амьжиргааны түвшинг хот, хөдөөгөөр авч үзэхэд ялгаа бага байгаа ч гэсэн улсын хэмжээнд шилжин суурьшигчид шилжин суурьшиж байгаагүй хүн амтай харьцуулахад ядууралд бага орсон байна.

Өрхийн эзэмшиж буй хөрөнгийн байдал нь тэднийг эдийн засгийн баталгаагүй байдлаас хамгаалж байдаг ба Монгол Улсын дийлэнхи хүн амын үндсэн хөрөнгө нь мал юм. Ядуу хүн амд ногдох малын дундаж тоо ядуу бус хүн амынхаас хоёр дахин цөөн байна. Мал малладаг өрхүүдийн ядуурлын түвшин зөвхөн хөдөөд л доогуур байна. Гэхдээ аль ч бүсийн хувьд өрх нь олон малтай байх тусам ядууралд бага өртсөн байна. Мөнгөн санхүүгийн хөрөнгөтэй өрхүүдийн хувьд ядууралд өртөх нь мөнгөн хөрөнгө болон хадгаламжгүй өрхүүдээс нилээд бага байна.

Хот суурин газрынхны хувьд өрхийн сууцны нөхцөл нь ядууралд илүүтэйгээр нөлөөлж байна. Хот суурин газарт гэр хорооллынхонтой харьцуулахад байшин сууцанд амьдрагчдын дунд ядууралд хамрагдах нь бага байхад хөдөөд сууцны тусдаа байшинд амьдардаг өрхүүд гэрт амьдардаг өрхүүдтэй харьцуулахад ядууралд илүү өртсөн байна. Дэд бүтцийн үйлчилгээний хувьд үүнтэй ойролцоо

дүр зураг гарч байна. Хотод сайжруулсан усан хангамж, ариун цэврийн байгууламж, цахилгаан эрчим хүчний хангамжтай өрхүүд нь ядууралд бага өртөж байхад хөдөөд ямар нэг тодорхой хандлага ажиглагдахгүй байна. Ялангуяа хотын болон ядуу бус хүн ам нь эдгээр 3 үйлчилгээний аль нэгийг хүртэж байна.

### **Ядуурал ба боловсрол**

Насанд хүрсэн хүн амын боловсролын түвшин өндөр байна. Нийт хүн амын гуравны нэг нь дээд болон тусгай мэргэжлийн боловсролтой байна. Ядуучуудын боловсролын түвшин, ядуу бус хүн амынхаас доогуур буюу ядуучуудын талаас илүү хувь нь дөнгөж бүрэн бус дунд (суурь) боловсролтой байхад ядуу бус хүн амынхны гуравны нэг нь энэ түвшний боловсролтой байна. Улсын төсвөөс боловсролд зарцуулсан зардлын хэмжээг авч үзэхэд бага боловсролын хувьд шууд, дунд боловсролын хувьд дийлэнхидээ тогтмол хамааралтай, харин дээд боловсролын хувьд урвуу хамааралтай байв. Ядуу болон ядуу бус хүн амын бага сургуульд хамрагдалтын түвшин ойролцоо байхад харин дунд шатны сургуульд хамрагдалтын түвшин ядуу бус хүн амын дунд өндөр байна. Төрийн өмчийн бага болон дунд шатны сургуульд суралцагч ядуу бус хүн ам нь боловсролдоо ядуу хүн амынхаас дунджаар 60 хувиар илүү зардал зарцуулж байна.

### **Ядуурал ба эрүүл мэнд**

Өвчлөлийн түвшин маш доогуур буюу судалгаанд хамрагдсан хүн амын зөвхөн 6 хувь нь л судалгааны өмнөх сард өвчилсөн гэж хариулсан байна. Ядуу бус хүн ам ядуучуутай харьцуулахад илүү өвчилсөн гэж мэдээлэх нь их байдаг бөгөөд энэ ялгаа настай хүмүүсийн дунд бүр ч их болж байна. Ядуу бус хүн ам өвчилбөл эмчилгээний олон арга замыг илүүтэйгээр хайдаг байна. Хотын ядуу бус хүн ам нь хувийн эмнэлэгт илүү олон ханддаг ба харин өвчтөний хувьд ядуу болон ядуу бус хүн амын аль аль нь эмчид ханддаг байна. Ядуу бус хүмүүс эрүүл мэнддээ ядуучуудаас 3 дахин их зардал зарцуулжээ. Хүн амын хамгийн чинээлэг бүлгийнхний (20%) нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардлын хэмжээ нь хамгийн ядуу 20 хувийнхнаас 7 дахин их байна. Бэлгийн замаар дамжих халдварт өвчний талаарх мэдлэг хүн амын амьжирааны аль ч бүлгийнхний дунд жигд байгаа ч тухайн өвчинөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар харин ядуу бус хүн ам илүү мэдлэгтэй байна. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хувьд ядуу болон ядуу бус эмэгтэйчүүдийн аль аль нь жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, хэрэгсэлийг хэрэглэдэг, жирэмсэн эмэгтэйчүүд ч эмнэлгийн хяналтанд адилхан хамрагддаг байна. Харин ядуу эмэгтэйчүүдийн хувьд үр хөндүүлэх тохиолдол цөөн хэдий ч шаардлагатай тохиолдолд гол нь санхүүгийн гачигдлаас шалтгаалж үр хөндүүлдэг байна.

### **Ядуурал ба хөдөлмөрийн зах зээл**

Ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувь байна. Хот суурин газарт ажиллах хүчний оролцооны түвшин хөдөөгийнхөөс маш бага буюу энэ үзүүлэлт хотод

тавны гурав, хөдөөд дөрөвний гурав байна. Ядуучуудын ажил эрхлэлтийн түвшин ч ядуу бус хүн амынхаас доогуур байна. Хүн амын ажил эрхэлж байгаа эдийн засгийн салбарын байдал ч хот, хөдөөд харилцан адилгүй байна. Хөдөөд 10 хүний 7 нь мал аж ахуй эрхэлж байхад нийслэл хот, аймгийн төвд ажиллагсдын дөрөвний гурав нь үйлчилгээний салбарт ажиллаж байна. Малчин, газар тариаланч нар ядууралд илүү өртөмтгий байхад ядуу бус хүн амын ихэнхи нь менежер, техникч, мэргэжилтэй ажилтан байна. Ажилгүйдлийн түвшин хот, хөдөөд ойролцоо, харин ядуу бус хүн амтай харьцуулахад ядуучуудын дунд хоёр дахин их байна.

### **Ядуурал ба нийгмийн хамгаалал**

Нийгмийн хамгааллын сүлжээнд хүн амын хамрагдалтын хүрээ маш өндөр, 5 өрх тутмын 4 нь ямар нэг тэтгэвэр, тэтгэмж, тусlamж бусдаас хүлээн авсан эсвэл бусдад өгсөн байна. Нийт өрхийн 70 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг, хандив, тусlamж хүлээн авсан байхад тал хувь нь бусдад тусlamж өгчээ. Өрхийн хүлээн авсан улсын болон хувийн шилжүүлгийн хэмжээ ойролцоо байгаа боловч улсын шилжүүлэг нийт шилжүүлгийн бараг дөрөвний гурвыг бүрдүүлж байна. Тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамжийн сангаас болон бусдаас хандив, тусlamж хүлээн авсан болон аваагүй өрхүүдийн ядууралд хамрагдах хүрээ ойролцоо байгаа ч өрхийн хүлээн авч байгаа тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг, хандив, тусlamжийн хэмжээ их байх тутам тэдгээр өрхийн ядууралд өртөх нь бага байна.

**Жич: Уг судалгааг бүрэн эхээр нь Нээлттэй Нийгэм Форумын Хөгжлийн Мэдээллийн төв болон Үндэсний Статистикийн Газар дээр ирж үзнэ үү.**